

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ДОА-2025/014/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
- 3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.27 № 415

танай _____-ны № _____-т

БАЯНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БАТХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяндун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Наранбулаг хөгжил" ОНӨААТҮГ нь 2024 онд үйл ажиллагаа огт явуулаагүй, "Х"-тайлан ирүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сумын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг "Хангалтгүй" гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011022199

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	786,700.20	1,157,830.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	413,032.10	565,342.90
33	АВЛАГА	147,768.90	93,800.30
35	БАРАА МАТЕРИАЛ	225,899.30	498,687.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,163,096.20	3,464,964.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,163,096.20	3,464,964.60
39200	Биет хөрөнгө	2,799,571.50	3,010,323.00
39300	Биет бус хөрөнгө	363,524.80	454,641.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,949,796.50	4,622,795.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,949,796.50	4,622,795.40
51	Засгийн газрын хувь оролцоо	3,949,796.50	4,622,795.40
51100	Засгийн газрын оруулсан капитал	921,215.00	921,215.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,586,220.90	3,259,219.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,360.60	442,360.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,949,796.50	4,622,795.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,756,033.10	3,229,022.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	771,108.20	1,159,789.50
110	Орлогын албан татвар	470,235.20	952,370.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	480,170.80	983,138.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,935.60	-30,768.70
113	Хөрөнгийн албан татвар	65,748.00	74,694.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	235,125.10	132,724.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,133,203.60	931,585.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,112,503.60	922,753.60
121	Хөрөнгийн орлого	0	0
122	Тусламжийн орлого	20,700.00	8,831.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,851,721.30	1,137,647.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,151,747.50	1,613,745.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,151,747.50	1,613,745.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,057,221.90	1,523,434.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,747.10	660,581.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,914.00	77,825.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,103.60	173,437.70
2104	Хангамж, бараа материалын зардал	55,057.00	61,885.00
2105	Нормативт зардал	46,259.60	33,782.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,867.60	24,632.20
2107	Томиллолт, зочны зардал	10,724.00	12,682.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,602.70	14,318.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	319,946.40	464,289.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,094,525.60	90,311.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,604,285.60	1,615,276.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,106,471.50	940,777.70
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	497,814.00	674,498.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,181,982.40	3,181,982.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,181,982.40	3,181,982.40
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	270,000.00	270,000.00
9	Тайлант үеийн үр дүн	497,814.00	497,814.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,949,796.50	3,949,796.50
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,949,796.50	3,949,796.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,500.00	-1,500.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,948,296.50	3,948,296.50
19	Тайлант үеийн үр дүн	674,498.90	674,498.90
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,622,795.40	4,622,795.40

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,704,538.90	2,380,342.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	771,108.20	1,159,789.50
110	Орлогын албан татвар	470,235.20	952,370.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	480,170.80	983,138.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,935.60	-30,768.70
113	Хөрөнгийн албан татвар	65,748.00	74,694.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	235,125.10	132,724.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,405.60	4,869.30
1181	Газрын төлбөр	212,314.40	120,595.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	17,405.10	7,260.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,709.40	82,905.10
120	Нийтлэг татварын бус орлого	61,009.40	74,073.30
122	Тусламжийн орлого	20,700.00	8,831.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,851,721.30	1,137,647.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,836,924.90	1,249,937.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,836,924.90	1,249,937.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,399.20	1,159,625.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,747.10	660,581.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,046.00	77,693.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,103.60	178,624.90
2104	Хангамж, бараа материалын зардал	39,864.30	46,393.60
2105	Нормативт зардал	1,354.00	1,017.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,440.10	29,722.00
2107	Томиллолт, зочны зардал	10,724.00	12,867.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,602.70	22,318.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,517.40	130,406.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,094,525.60	90,311.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	867,614.00	1,130,404.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	894,685.60	978,094.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	894,685.60	978,094.00
2200	Дотоод эх үүсвэрээр	894,685.60	978,094.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-894,685.60	-978,094.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-27,071.60	152,310.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	440,103.70	413,032.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	413,032.10	565,342.90

**БАЯНДУН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,471,589.80	2,110,709.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,274,936.10	1,148,135.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,224,153.30	1,097,824.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	691,855.60	660,014.80
210101	Үндсэн цалин	601,070.00	380,492.90
210102	Нэмэгдэл	4,797.50	225,204.30
210104	Урамшуулал	38,353.30	34,650.00
210105	Гэрээт ажлын хөлс	47,634.80	19,667.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,487.70	77,693.20
210201	Тэтгэврийн даатгал	58,060.10	52,326.50
210202	Тэтгэмжийн даатгал	6,827.40	6,219.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,675.00	3,820.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,508.60	3,334.70
210205	Эрүүл мэндийн даатгал	14,416.60	11,992.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,923.10	178,624.90
210301	Гэрэл, цахилгаан	76,159.10	75,835.30
210302	Түлш, халаалт	100,912.00	100,251.80
210303	Цэвэр, бохир ус	2,852.00	2,537.80
2104	Хангамж, бараа материалын зардал	35,118.00	39,281.20
210401	Бичиг хэрэг	4,297.20	4,320.00
210402	Тээвэр, шатахуун	23,304.80	27,704.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,189.90	2,117.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,326.10	5,139.20
2105	Нормативт зардал	1,020.00	1,017.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,020.00	1,017.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,185.40	29,722.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,822.00	1,821.50
210604	Урсгал засвар	28,363.40	27,900.60
2107	Томилолт, зочны зардал	10,727.50	10,727.50
210702	Дотоод албан томилолт	10,727.50	10,727.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,553.40	7,370.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,313.40	5,131.10
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240.00	1,240.00
210807	Газрын төлбөр	1,000.00	999.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,282.60	93,372.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	181,282.60	93,372.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,782.80	50,311.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,782.80	50,311.50
213205	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх тэтгэмж	33,684.00	33,212.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,098.80	17,098.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,096,653.70	962,574.00
223001	Бусад хөрөнгө	1,096,653.70	962,574.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.00	0
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000.00	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,471,589.80	2,129,403.80
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,060,200.90	2,054,673.40
320001	Орон нутгийн төсвөөс	1,203,510.60	1,243,644.70
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	856,690.30	811,028.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	390,557.10	65,898.60
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.00	46,248.60
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600.00	19,650.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	384,957.10	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0	0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	20,831.80	8,831.80
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	20,831.80	8,831.80
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	284,732.80
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	303,427.10

**БАЯНДУН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60	55
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	24
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	6
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,826.70	117,321.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,826.70	117,321.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,826.70	77,321.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,626.90	567.00
210104	Урамшуулал	1,626.90	567.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,415.90	0.00
210301	Гэрэл, цахилгаан	4,415.90	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,778.90	7,632.40
210401	Бичиг хэрэг	246.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	8,278.90	6,920.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,254.00	711.50
2107	Томилголт, зочны зардал	540.00	2,140.00
210702	Дотоод албан томилголт	540.00	2,140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	0.00	14,947.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	0.00	14,947.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,465.00	52,034.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,465.00	52,034.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,000.00	40,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,000.00	40,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,000.00	40,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	98,826.80	117,321.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,826.80	117,321.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	0.00	33,219.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,616.20	53,107.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,210.60	30,994.10
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 69.1 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

Илрүүлэлт: Сумын нийт орлого 1,168.0 сая төгрөг болж 173.6 сая төгрөг буюу 17.5 хувиар давж биелсэн байна. Гэвч газрын төлбөрийн орлого 19.4 хувь буюу 29.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг нэр төрлөөр нь ханган ажиллах зөвлөмж өгөв.

2. Хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн

Илрүүлэлт: Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 40.0 сая төгрөг /цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж/-ийн 1 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төлөвлөгөөт ажлыг бүрэн хийж, төсвийн захирагчийн хүрэх үр дүнг ханган ажиллах зөвлөмж өгөв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүрэх үр дүнг ханган ажиллаагүй	1	40.0	-	-	-	-	1	40.0
Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэн ажиллаагүй	1	29.1	-	-	-	-	1	29.1
Нийт дүн	2	69.2	-	-	-	-	2	69.2